

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 05 дүгээр сарын 24 ныг өдрийн  
...3... дугаар тогтоолын Хавсралт 1



## ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Иншүрко даатгал ХХК /цаашид “компани” гэх/-ийн Эрсдэлийн удирдлагын талаар баримтлах бодлого, үйл ажиллагааг энэхүү баримт бичгээр тодорхойлно.
- 1.2. Энэхүү баримт бичиг нь Компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

### Хоёр. Эрсдэлийн удирдлагын бодлого

- 2.1. Эрсдэлийн удирдлагын бодлогын үзэл баримтлал:
  - 2.1.1. Эрсдэлийн удирдлага нь компанийн урт хугацааны тогтвортой үйл ажиллагааны баталгааг хангана.
  - 2.1.2. Эрсдэлийн удирдлагыг компанийн бүхий л үйл ажиллагаанд, нийт ажилтан бүрийг хамааруулан хэрэгжүүлнэ.
  - 2.1.3. Эрсдэлийн удирдлагын бодлого нь компанийн бизнес төлөвлөгөөний хугацаатай уялдаатай байна.
  - 2.1.4. Эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, бууруулах, хянах, удирдах үйл ажиллагаа нь хараат бус, ил тод байдлаар явуулах боломжоор хангагдсан байна.
- 2.2. Эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа дараах 4 үе шаттай байна:
  - 2.2.1. Эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, түвшинг тогтоох;
  - 2.2.2. Эрсдэлийн үнэлгээний тайлан бэлтгэх, тайлагнах;
  - 2.2.3. Эрсдэлд хариу арга хэмжээ авах;
  - 2.2.4. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих.
- 2.3. Энэ баримт бичгийн 2.2.1-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ирээдүйд учирч болзошгүй нийт эрсдэл /Risk Exposure/, үүнээс хүлээн авч чадах эрсдэл /Risk appetite/, хүлээж авах эрсдэл буюу эрсдэлийн багц /Risk Profile/-ын тодорхойлолт, хэмжээ болон хамрах хүрээг тогтоох бөгөөд “Иншүрко даатгал ХХК-ийн Эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлал”-д үндэслэн тодорхойлно.
- 2.4. Энэ баримт бичгийн 2.2.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ “Иншүрко даатгал ХХК-ийн Эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлан” /цаашид “Эрсдэлийн үнэлгээний тайлан” гэх/-г хамгийн багадаа жилд нэг

удаа гаргах бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын 08-ны 559 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын хорин дөрөвдүгээр хавсралт “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ын 4-т заасны дагуу гүйцэтгэнэ.

- 2.5. Энэ баримт бичгийн 2.2.3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ эрсдэл хариуцсан газар, нэгж нь дээрх аргачлалын 3.7-д заасны дагуу эрсдэлийг ангилж, үр дүнд гарсан бууруулах эрсдэл болон яаралтай арга хэмжээ авч бууруулах эрсдэлүүдэд холбогдох газар, нэгжийн хамт эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг боловсруулж, эрсдэлийн үнэлгээний тайланд тусган, эрсдэлийн хороонд танилцуулж, эрсдэлийн хорооноос гаргасан шийдвэрийг холбогдох газар, нэгжүүдэд хүргэж, эрсдэлийг бууруулах үүрэг өгч ажиллана.
- 2.6. Энэ баримт бичгийн 2.2.4-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн хороо, дотоод хяналт, эрсдэл хариуцсан газар, нэгж нь энэ баримт бичгийн 2.5-д заасан хариу арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж, хяналт тавин ажиллана.
- 2.7. Эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх хамгаалалтын гурван шугамтай байна.
  - 2.7.1. Хамгаалалтын нэгдүгээр шугам нь компанийн газар, нэгжийн бүх ажилтнууд байх бөгөөд энэ баримт бичгийн 2.8.4 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.
  - 2.7.2. Хамгаалалтын хоёрдугаар шугам нь эрсдэл хариуцсан газар, хэлтэс байх бөгөөд энэ баримт бичгийн 2.8.3 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.
  - 2.7.3. Хамгаалалтын гуравдугаар шугам нь эрсдэлийн хороо болон дотоод аудит байх бөгөөд энэ баримт бичгийн 2.8.2 болон 2.8.5 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.
- 2.8. Эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэгчдийн чиг үүрэг:
  - 2.8.1. Төлөөлөн удирдах зөвлөл:
    - 2.8.1.1. Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг болон аргачлалыг батлах;
    - 2.8.1.2. Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг болон аргачлалын хэрэгжилтэд хяналт тавих;
    - 2.8.1.3. Эрсдэлийн удирдлагын үр ашигт байдалд дүгнэлт хийх.
  - 2.8.2. Эрсдэлийн хороо:
    - 2.8.2.1. Эрсдэлийн үнэлгээний тайлан, холбогдох санал, дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

- 2.8.2.2. Компанийн хэвийн тогтвортой үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг тодорхойлох, шийдвэр гаргах;
  - 2.8.2.3. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангуулж, хянах, үр дүнтэй байдлыг үнэлэх, шаардлагатай гэж үзвэл хариуцлага тооцох шийдвэр гаргах;
  - 2.8.2.4. Шаардлагатай гэж үзвэл Эрсдэлийн үнэлгээний тайланг гаргах хугацааг тодорхойлох;
  - 2.8.2.5. Эрсдэлийг бууруулахад шаардлагатай санхүү болон төсвийн асуудлыг шийдвэрлэх;
  - 2.8.2.6. Шаардлагатай тохиолдолд болзошгүй эрсдэлийн дараах үйл явдалд зориулсан нэмэлт санхүүжилтийг олох боломж, авах арга хэмжээний төлөвлөгөө, эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааны талаар шийдвэр гаргах.
- 2.8.3. Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж:
- 2.8.3.1. Энэ баримт бичгийн 2.3-т заасан аргачлалд үндэслэн компанийн эрсдэлийг илрүүлэн, үнэлж, бууруулах, хянах арга хэмжээг тодорхойлох;
  - 2.8.3.2. Энэ баримт бичгийн 2.4-т заасан эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулах, дотоод аудитын дүгнэлтийн хамт Эрсдэлийн хороонд тайлагнах;
  - 2.8.3.3. Эрсдэлийг бууруулах, хянах зорилгоор Эрсдэлийн хорооноос гаргасан эрсдэлийн хариу арга хэмжээний талаар шийдвэрийг холбогдох газар, нэгжүүдэд хүргүүлэх, танилцуулах;
  - 2.8.3.4. Эрсдэлийн хорооноос өгсөн үүрэг даалгаврын дагуу эрсдэл бууруулах, хянахтай холбоотой хийсэн ажлын тайланг нэгтгэн, дотоод аудитын дүгнэлтийн хамт Эрсдэлийн хороонд танилцуулах;
  - 2.8.3.5. Эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, бууруулах арга хэмжээг тодорхойлохтой холбоотой асуудалд бусад газар, нэгжүүдэд шаардлагатай, үнэн зөв мэдээллээр хангах, заавар, зөвлөгөө өгөх;
  - 2.8.3.6. Компанид эрсдэлийн удирдлагын соёлыг түгээх.
- 2.8.4. Эрсдэл хариуцсан газар, нэгжээс бусад компанийн газар, нэгж:
- 2.8.4.1. Энэ баримт бичгийн 2.3-т заасан аргачлалд үндэслэн эрсдэл хариуцсан газар, нэгжийн заасан хугацаанд өөрсдийн эрсдэлийг илрүүлэн, үнэлж, бууруулах, хянах арга хэмжээг тодорхойлох;

2.8.4.2. Эрсдэлийг бууруулах, хянах зорилгоор Эрсдэлийн хорооноос гаргасан эрсдэлийн хариу арга хэмжээний талаар шийдвэрийг дагаж мөрдөн, хэрэгжүүлж ажиллах;

2.8.4.3. Эрсдэлийн хорооноос өгсөн үүрэг даалгаврын дагуу эрсдэл бууруулах, хянахтай холбоотой хийсэн ажлын тайлан, дүгнэлтийн хамт эрсдэл хариуцсан газар, нэгжид хүргүүлэх;

2.8.4.4. Шаардлагатай тохиолдолд эрсдэл хариуцсан газар, нэгжийн шаардсаны дагуу эрсдэлийн тайлагнал, мэдээллээр хангах.

2.8.5. Дотоод аудит:

2.8.5.1. Эрсдэлийн үнэлгээний тайланд үнэлэлт, дүгнэлт өгөх, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

2.8.5.2. Эрсдэлийг бууруулах, хянах зорилгоор Эрсдэлийн хорооноос гаргасан тогтоол, шийдвэрийн талаар дүгнэлт өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

2.8.5.3. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хараат бус, бие даасан хяналтыг хэрэгжүүлэн, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгөх;

2.8.5.4. Эрсдэлийн хорооноос өгсөн үүрэг даалгаврын дагуу эрсдэл бууруулах, хянахтай холбоотой хийсэн ажлын тайланд дүгнэлт өгөх;

2.8.5.5. Эрсдэлийн удирдлагын бодлого болон эрсдэлийн үнэлгээний аргачлалын зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр зөвлөмж, үнэлгээ өгөх;

### **Гурав. Эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлан**

3.1. Эрсдэлийн үнэлгээний тайлан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн 559 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын хорин дөрөвдүгээр хавсралт “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ын 4.2-т заасан шаардлагыг хангасан байна.

3.2. Эрсдэлийн үнэлгээний тайланг дээрх зааврын хавсралт “Эрсдэлийн үнэлгээний тайлангийн товч” болон дотоод аудитын дүгнэлтийн хамт Эрсдэлийн хороо болон холбогдох эрх бүхий албан тушаалтан танилцуулж, дараа оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

3.3. Шаардлагатай тохиолдолд Эрсдэлийн хороо болон Санхүүгийн зохицуулах хорооны шаардлагын дагуу Эрсдэлийн үнэлгээний тайланг бүрэн болон хэсэгчилсэн хэлбэрээр хэдийд ч гаргаж өгч болно.

## Дөрөв. Бусад зүйл

- 4.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороо энэ баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавина.
- 4.2. Даатгагч нь зах зээлийн нөхцөл байдал, салбарын хөгжлийн чиг хандлага болон өөрийн бизнесийн, санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, бодлогын баримт бичигтээ жил бүр дүгнэлт хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулж, шинэчилсэн бодлогын баримт бичгийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулна.
- 4.3. Даатгагч бодлогын баримт бичгийг анх батлах болон түүнд өөрчлөлт оруулах тухай бүр батлагдсанаас хойш 14 хоногийн дотор Хороонд хүргүүлнэ.
- 4.4. Даатгагч энэ баримт бичгийн 2.2.1-д заасан үнэлгээг хийх явцад даатгагчийн төлбөрийн чадвар болон даатгалын нөөц санд холбогдох эрсдэл үүссэн тохиолдолд энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 4.5. Компани энэ баримт бичигт тусгагдаагүй эрсдэлийн удирдлагын бодлоготой холбоотой аливаа асуудлыг Даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.
- 4.6. Энэ баримт бичгийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.

---oOo---